

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/78/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батсайхан Утас: 70453799, Цахим хаяг: batsaikhanS@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.25 № УМ-2022/78/КА-СТА-ТЦЗ
танай _____-ны № _____-т

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ТӨВИЙН ДАРГА Г.ЭРДЭНЭДЭЛГЭР
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ

0200200311

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал.....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт.....	
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>30,136,199.78</u>	<u>33,273,584.78</u>
33	АВЛАГА	1,059,439.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,059,439.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	29,076,760.78	33,273,584.78
351	Түүхий эд материал	11,672,583.50	10,630,550.00
35130	Эм боох материал	11,672,583.50	10,630,550.00
354	Хангамжийн материал	17,404,177.28	22,643,034.78
35410	Бичиг хэргийн материал	546,300.00	1,080,800.00
35420	Аж ахуйн материал	6,949,030.00	4,443,500.00
35470	Бусад хангамжийн материал	9,908,847.28	17,118,734.78
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>195,606,760.27</u>	<u>181,471,033.73</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	195,606,760.27	181,471,033.73
392	Биет хөрөнгө	127,936,760.27	113,884,367.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	102,594,055.00	102,594,055.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-26,106,301.00	-29,326,358.44
39203	Авто-тээврийн хэрэгсэл	82,060,000.00	82,060,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-42,603,333.41	-52,068,333.41
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	90,992,380.60	89,380,954.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	-81,340,040.88	-81,136,950.19
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,627,104.94	15,407,664.94
39208	Хуримтлагдсан элэгдэл	-13,287,104.98	-13,026,665.04
39214	Бусад үндсэн хөрөнгө	420,500.00	420,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-420,500.00	-420,500.00
393	Биет бус хөрөнгө	67,670,000.00	67,586,666.72
39301	Програм хангамж	250,000.00	250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-83,333.28
39303	Бусад биет бус хөрөнгө	67,420,000.00	67,420,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>225,742,960.05</u>	<u>214,744,618.51</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>225,742,960.05</u>	<u>214,744,618.51</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	225,742,960.05	214,744,618.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	175,217,827.00	175,217,827.00
51101	Өмч: - төрийн	175,217,827.00	175,217,827.00
512	Хуримтлагдсан үр дүн	35,849,507.93	24,859,716.84
51210	Өмнөх үеийн үр дүн	35,849,507.93	35,858,058.38
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-10,998,341.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	14,675,625.12	14,667,074.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>225,742,960.05</u>	<u>214,744,618.51</u>

2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	405,066,231.50	442,297,913.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,406,931.50	10,317,509.55
120	Нийтлэг татварын бус орлого	31,406,931.50	10,317,509.55
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	31,406,931.50	10,317,509.55
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	31,406,931.50	10,317,509.55
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	373,659,300.00	431,980,404.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	370,686,300.00	391,850,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	370,686,300.00	391,850,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,973,000.00	40,130,404.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,973,000.00	40,130,404.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	383,785,009.05	453,296,255.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	380,125,746.05	424,155,186.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	380,125,746.05	424,155,186.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	265,605,593.00	288,763,445.27
210101	Үндсэн цалин	176,785,370.00	160,678,939.64
210102	Нэмэгдэл	50,369,422.00	86,750,218.39
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,363,000.00	11,859,000.00
210104	Урамшуулал	26,087,801.00	29,475,287.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,071,213.00	40,152,309.68
210201	Тэтгэврийн даатгал	22,795,413.00	26,732,627.03
210202	Тэтгэмжийн даатгал	2,462,700.00	2,968,724.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,956,900.00	5,221,468.26
210204	Ажилгүйдлийн даатгал	532,400.00	475,409.15
210205	Эрүүл мэндийн даатгал	5,323,800.00	4,754,080.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,800,309.00	10,024,887.00
210301	Гэрэл, цахилгаан	1,500,309.00	1,372,887.00
210302	Түлш, халаалт	6,860,000.00	7,350,000.00
210304	Байрны түрээс	1,440,000.00	1,302,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,448,983.00	16,403,886.00
210401	Бичиг хэрэг	1,214,700.00	742,950.00
210402	Тээвэр, шатахуун	11,953,740.00	13,721,840.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,072,093.00	827,406.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	76,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	208,450.00	1,035,690.00
2105	Нормативт зардал	20,462,424.40	33,812,295.55
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,462,424.40	31,931,795.55
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,880,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,475,550.00	7,362,350.00
210604	Урсгал засвар	5,475,550.00	7,362,350.00

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	9,034,000.00	9,237,000.00
210702	Дотоод албан томилолт	9,034,000.00	9,237,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,152,540.00	3,246,286.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	167,500.00	910,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	160,740.00	262,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	186,600.00	185,836.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	737,500.00	768,000.00
210807	Газрын төлбөр	674,200.00	674,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,075,133.65	15,152,726.54
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,075,133.65	15,152,726.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,659,263.00	29,141,069.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	380,000.00	26,280,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	25,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	380,000.00	1,080,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,279,263.00	2,861,069.05
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,279,263.00	2,861,069.05
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	21,281,222.45	-10,998,341.54
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	21,281,222.45	-10,998,341.54

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	373,659,300.00	431,980,404.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	373,659,300.00	431,980,404.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	370,686,300.00	391,850,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	370,686,300.00	391,850,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,973,000.00	40,130,404.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,973,000.00	40,130,404.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	373,659,300.00	431,980,404.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	373,659,300.00	431,980,404.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	263,138,945.00	287,704,006.27
210101	Үндсэн цалин	163,010,722.00	170,068,727.40
210102	Нэмэгдэл	60,522,422.00	76,300,991.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,518,000.00	12,576,000.00
210104	Урамшуулал	26,087,801.00	28,758,287.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,597,300.00	40,152,309.68
210201	Тэтгэврийн даатгал	25,287,800.00	26,732,626.16
210202	Тэтгэмжийн даатгал	2,661,900.00	2,968,724.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,791,400.00	5,221,468.26
210204	Ажилгүйдлийн даатгал	532,400.00	475,409.15
210205	Эрүүл мэндийн даатгал	5,323,800.00	4,754,081.29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,800,309.00	10,024,887.00
210301	Гэрэл, цахилгаан	1,500,309.00	1,372,887.00
210302	Түлш, халаалт	6,860,000.00	7,350,000.00
210304	Байрны түрээс	1,440,000.00	1,302,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,064,033.00	19,140,096.00
210401	Бичиг хэрэг	853,200.00	799,450.00
210402	Тээвэр, шатахуун	11,953,740.00	13,813,340.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,072,093.00	827,406.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	800,000.00	1,700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,385,000.00	1,999,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,482,000.00	2,950,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,064,050.00	10,676,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,485,000.00	4,485,000.00
210604	Урсгал засвар	5,579,050.00	6,191,750.00
2107	Томилолт, зочны зардал	9,034,000.00	9,237,000.00
210702	Дотоод албан томилолт	9,034,000.00	9,237,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,402,540.00	3,246,286.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	167,500.00	914,300.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	320,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	160,740.00	262,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	186,600.00	185,836.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	987,500.00	768,000.00
210807	Газрын төлбөр	674,200.00	674,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,659,263.00	29,141,069.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	380,000.00	26,280,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	25,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	380,000.00	1,080,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,279,263.00	2,861,069.05
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,279,263.00	2,861,069.05
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	01.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	01.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	01.00	00.00

2.4. Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	175,217,827.00	14,715,405.12	-62,660,301.71	127,272,930.41
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	175,217,827.00	14,715,405.12	-62,660,301.71	127,272,930.41
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	77,188,807.19	77,188,807.19
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	175,217,827.00	14,675,625.12	35,849,507.93	225,742,960.05
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	175,217,827.00	14,675,625.12	35,849,507.93	225,742,960.05
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	8,550.45	8,550.45
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	175,217,827.00	14,675,625.12	35,858,058.38	225,751,510.50
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-8,550.45	00.00	-8,550.45
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-10,998,341.54	-10,998,341.54
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	175,217,827.00	14,667,074.67	24,859,716.84	214,744,618.51

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН				
		391,850,000.00	387,693,077.34	4,156,922.66	98.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	391,850,000.00	387,693,077.34	4,156,922.66	98.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	390,724,000.00	386,613,077.34	4,110,922.66	98.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	276,521,500.00	276,459,968.77	61,531.23	99.98
210101	Үндсэн цалин	173,279,600.00	170,068,727.40	3,210,872.60	98.15
210102	Нэмэгдэл	63,390,000.00	65,056,954.13	-1,666,954.13	102.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,860,000.00	12,576,000.00	1,284,000.00	90.74
210104	Урамшуулал	25,991,900.00	28,758,287.24	-2,766,387.24	110.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,095,500.00	38,469,589.57	1,625,910.43	95.94
210201	Тэтгэврийн даатгал	26,269,500.00	25,566,881.01	702,618.99	97.33
210202	Тэтгэмжийн даатгал	2,765,200.00	2,856,332.07	-91,132.07	103.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,977,400.00	5,019,160.93	-41,760.93	100.84
210204	Ажилгүйдлийн даатгал	553,000.00	457,020.06	95,979.94	82.64
210205	Эрүүл мэндийн даатгал	5,530,400.00	4,570,195.50	960,204.50	82.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,408,300.00	10,024,887.00	383,413.00	96.32
210301	Гэрэл, цахилгаан	1,650,200.00	1,372,887.00	277,313.00	83.20
210302	Түлш, халаалт	8,758,100.00	7,350,000.00	1,408,100.00	83.92
210304	Байрны түрээс	00.00	1,302,000.00	-1,302,000.00	#DIV/0!
2104	Хангамж, бараа материалын зардал	19,227,400.00	19,140,096.00	87,304.00	99.55
210401	Бичиг хэрэг	800,000.00	799,450.00	550.00	99.93
210402	Тээвэр, шатахуун	13,733,400.00	13,813,340.00	-79,940.00	100.58
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,194,000.00	827,406.00	366,594.00	69.30
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,500,000.00	1,700,000.00	-200,000.00	113.33
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	1,999,900.00	100.00	100.00
2105	Нормативт зардал	20,950,000.00	19,358,500.00	1,591,500.00	92.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,000,000.00	16,408,500.00	1,591,500.00	91.16
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,950,000.00	2,950,000.00	0.00	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,685,000.00	10,676,750.00	8,250.00	99.92
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,485,000.00	4,485,000.00	0.00	100
210604	Урсгал засвар	6,200,000.00	6,191,750.00	8,250.00	99.87
2107	Томилолт, зочны зардал	9,240,000.00	9,237,000.00	3,000.00	99.97
210702	Дотоод албан томилолт	9,240,000.00	9,237,000.00	3,000.00	99.97

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,596,300.00	3,246,286.00	350,014.00	90.27
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,024,000.00	914,300.00	109,700.00	89.29
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	320,000.00	0.00	100
210803	Даатгалын үйлчилгээ	263,000.00	262,950.00	50.00	99.98
210804	Тээврийн хэрэгслийн татвар	203,000.00	185,836.00	17,164.00	91.54
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	121,000.00	121,000.00	0.00	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	990,000.00	768,000.00	222,000.00	77.58
210807	Газрын төлбөр	675,300.00	674,200.00	1,100.00	99.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1126000.00	1080000.00	46,000.00	95.91
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,126,000.00	1,080,000.00	46,000.00	95.91
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,126,000.00	1,080,000.00	46,000.00	95.91
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	391,850,000.00	391,850,000.00	0.00	100
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	391,850,000.00	391,850,000.00	0.00	100

2.6. Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		39,834,757.61	-39834757.61	
21	УРСГАЛ ЗАРДАЛ		39,834,757.61	-39834757.61	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		14,634,757.61	-14634757.61	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		11,244,037.50	-11244037.50	
210102	Нэмэгдэл		11,244,037.50	-11244037.50	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,682,720.11	-1682720.11	
210201	Тэтгэврийн даатгал		1,165,745.15	-1165745.15	
210202	Тэтгэмжийн даатгал		112,392.75	-112392.75	
210203	ҮОМШӨ-ний даатгал		202,307.33	-202307.33	
210204	Ажилгүйдлийн даатгал		18,389.09	-18389.09	
210205	Эрүүл мэндийн даатгал		183,885.79	-183885.79	
2105	Нормативт зардал		1,708,000.00	-1708000.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		1,708,000.00	-1708000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	25200000.00	-25200000.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг		25,200,000.00	-25200000.00	
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		25,200,000.00	-25200000.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	40130404.00	-40130404.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		40,130,404.00	-40130404.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		40,130,404.00	-40130404.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр 06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Зоонозын өвчин судлалын төв нь 2021 онд байгалийн голомтот зоонозын халдварт өвчний тархвар судлал, тандалтын тогтолцоог өргөжүүлэх, лабораторийн үйл ажиллагааны чанарыг сайжруулах, эмч мэргэжилтнүүдийг дадлагажуулж сургах, шинжилгээ судалгааны ажлыг нэмэгдүүлэх гэсэн зорилтыг дэвшүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 453.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23902.0 мянган төгрөгөөр буюу 4.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	1,059.4	0.0	
Бараа материал	29,076.8	33,273.6	4,196.8
Үндсэн хөрөнгө	195,606.8	181,471.0	-14,135.8
Нийт хөрөнгө	225,742.9	214,744.6	-10998.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	225,742.9	214,744.6	-10998.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	225,742.9	214,744.6	-10998.3

Авлага дансны дансанд 1059.4 мянган төгрөгийн ажиллагсадтай холбогдсон авлага байсныг тайлант хугацаанд барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 33,273.6 мянган төгрөг болж 4,196.8 мянган төгрөгөөр өссөн нь бичиг хэрэг, бусад хангамжийн материал үлдэгдэлтэй байгаагаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 181,471.0 мянган төгрөг болж 14,135.8 мянган төгрөгөөр буурсан нь тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг акталж устгаснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь 1,017.0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, тавилга худалдан авснаар нэмэгдсэн, 2,847.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга акталж устгаснаар хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 214,744.6 мянган төгрөг болж 10998.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн алдагдалтай гарснаас шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 37231.7 мянган төгрөгөөр буюу 8.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан акталж, устгасан үндсэн хөрөнгө, бараа материал байна.

Нийт зардал өмнөх оноос 69,511.2 мянган төгрөгөөр буюу 15.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан цалин, нийгмийн даатгалын шимтгэл, эм, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 373,191.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 373,191.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 18,658.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 391,850.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалин, нийгмийн даатгалын шимтгэл, урамшуулал нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 391,850.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 388,570.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 391,850.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 387,693.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 387,693.0 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 20,130.4 мянга, улсын төсвөөс 20,000.0 мянга нийт 40,130.4 төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс нэмэгдэл цалинд 11,244.0 мянга, нийгмийн даатгалын шимтгэл 1,682.7 мянга, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл 1,708.0 мянга, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулалд 25,200.0 мянга нийт 39,834.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг хамруулан шалгасан.

Тус байгууллагын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс хугацаандаа оруулсан 144, хугацаа хоцроож 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт


Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  /С.БАТСАЙХАН/

2022 оны 02 сарын 22-ний өдөр